

МОНГОЛ УЛС
ҮНЭТ ЦААСНЫ ХОРООНЫ
ТОГТООЛ

1997 оны 03 дугаар
сарын 06-ны өдөр

Дугаар 22

Улаанбаатар
хот

Журам тогтоох тухай

Бүртгэл санхүү хөрөнгө оруулалтын хэлтсээс хийсэн шалгалтын дүн, Үнэт цаасны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол улсын Үнэт цаасны Хорооноос **ТОГТООХ** нь:

1. Монгол улсын хуулийн этгээд болох компанийн шинээр болон нэмж гарагасан үнэт цаасыг бүртгүүлэх зөвшөөрөл олгосон өдрөөс хойш нэг жилийн хугацаанд бүртгэгдсэн үнэт цаас нь арилжаалагдаагүй, төлбөр тооцоо нь хийгдээгүй бол бүртгүүлэх зөвшөөрлийг хүчингүйд тооцож, нийтэд мэдээлж байх журам тогтоосугай.

2. Энэ тогтоол гарахаас өмнө бүртгүүлэх зөвшөөрөл олгосон үнэт цаасны арилжаа, төлбөр тооцоо хийгдсэн байдлыг шалган, зохих арга хэмжээ авч, хорооны хуралдаанд оруулахыг Ажлын алба /Ж.Жадамбаа/, Хөрөнгийн бирж / О.Энхбаяр/ -д даалгасугай.

3. Тогтоосон журмыг нийтэд сурталчлах, биелэлтэд нь байнгын хяналт тавьж ажиллахыг Ажлын алба /Ж.Жадамбаа/-д даалгасугай.

ДАРГА

Ж.ЯДАМСҮРЭН